



**БАГАНУУР ДҮҮРГИЙН
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”
эх үрсийн баярыг тэмдэглэх, зардал
гаргах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын албан хаагчдын хүүхдүүдийн хүрээнд Олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”, эх үрсийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсугай.

2. Тус арга хэмжээний зардалд 1,000,000 /нэг сая/ төгрөгний төсвийг 1 дүгээр хавсралтаар баталж, Үйл ажиллагааны зардлыг холбогдох сангаас гаргахыг Нягтлан бодогч /Л.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

3. Баярын арга хэмжээний хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар баталж, өндөр түвшинд зохион байгуулж, тайлагнахыг байгууллагын “Гэр бүл, хүүхэд, залуучуудын зөвлөл” /Б.Мөнгөнхуяг/-д даалгасугай.

ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН